



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 118

Улаанбаатар хот

Төрийн өмчийн төлөөлөгчийг томилж,
удирдамж батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1.“Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр болох хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд төрийн өмчийг төлөөлөн оролцох төлөөлөгчөөр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн Т.Лхагвасүрэн нарыг томилсугай.

2.“Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд удирдамжийг баримтлан оролцох, хуралд оролцсон тайланг танилцуулахыг төрийн өмчийн төлөөлөгч Т.Лхагвасүрэнд даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА




3.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000260

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн
11:30 дугаар тогтоолын хавсралт



**“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД ТӨРИЙН
ӨМЧИЙГ ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦОХ ТӨЛӨӨЛӨГЧИЙН
БАРИМТЛАХ УДИРДАМЖ**

Төрийн өмчийн төлөөлөгч нь компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар шийдвэр гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам” болон энэхүү удирдамжийг баримтална:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлт өгч, гүйцэтгэх удирдлагад үүрэг даалгавар өгөх;

2. Компанийн 2019 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлттэй танилцаж үнэлэлт, дүгнэлт өгч, гүйцэтгэх удирдлагад үүрэг даалгавар өгөх;

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн дүгнэлтийг хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлт өгч, гүйцэтгэх удирдлагад үүрэг даалгавар өгөх;

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн энгийн болон хараат бус гишүүдийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгох;

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тусган батлах;

6. Орон сууц хувьчлах тухай асуудлыг хэлэлцэж Орон сууц хувьчлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь заалт болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхэд санал өгч оролцох.

-----оо-----